

НИЙСЛЭЛИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

“Хүүхдэд ээлтэй хот” Бүгд Найрамдах Филиппин Улсын
Манила, Давао хотод 2014 оны 09 дүгээр сарын 15-наас 19-ний хооронд
туршлага судалсан тухай

2014 оны 10 дугаар сарын 04

Улаанбаатар хот

НҮБ-ын Хүүхдийн төлөө байгууллагаас Бүгд Найрамдах Филиппин улсын Манила, Давао хотуудад 2014 оны 09 дүгээр сарын 13-наас 20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Хүүхдэд ээлтэй хотыг хэрхэн бий болгох, хот төлөвлөлтөд хүүхдийн асуудлыг хэрхэн авч үзэх” талаар туршлага судлах сургалтад миний бие, Хүүхдийн Төлөө Үндэсний газрын дарга И.Нарантуяа, НЗДТГ-ын СБТХ-ийн дарга С.Баярбаатар, НДЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Б.Эрдэнэцогт, Налайх дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төвийн дарга Б.Наранбаяр нарын хамт тус улсад томилолтоор ажилласан.

Томилолтоор ажиллах бид дараах үйл ажиллагаануудтай танилцаж, туршлага судалсан. Үүнд:

1. Хүүхдэд ээлтэй хөдөлгөөн, сайн туршлага
 - Хүүхдийн төлөөх үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө
 - Филиппин хүүхдүүдийн аж байдлыг сайжруулахад орон нутгийн засаг захиргааны үүрэг
 - Орон нутгийн сайн засаглалын аудит
 - Орон нутгийн “Хүүхдэд ээлтэй” сайн засаглалыг үнэлэж урамшуулах
 - Хүүхдэд ээлтэй санаачлагад ТББ-уудын үүрэг оролцоо
2. Хүүхдийн төлөөх үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө /2011-2016/

Төлөвлөгөөг **Хүүхдийн халамжийн Ерөнхий зөвлөлөөс** 5, 5 жилээр батлан хэрэгжүүлдэг.

Гурван зорилго дэвшүүлсэн. Үүнд:

- Хүүхэд, эхийн амьдралыг илүү чанартай болгох
 - Хүүхдийг үл хайхрах, хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах
 - Хүүхдүүдийг шийдвэр гаргах түвшинд оролцуулах
- Төлөвлөгөө хэрэгжсэнээр ХЭК, болон МХЗ-уудыг хангана гэж үзэж байна.
3. Хэрэгжүүлэх хөтөлбөр, стратеги:
 - Нийгмийн үйлчилгээний хүртээмж, тухайлбал, *мөнгөн тэтгэмж олгох, нэмэлт хоол тэжээлээр хангах, бага насны хүүхдэд чиглэсэн суурь боловсрол олгох, хөгжүүлэх иж бүрэн цэцэрлэгийн үйлчилгээ, нялхасын эрүүл мэнд, эхийн сүүгээр хооллохыг дэмжих, цэвэр ус ариун цэврийн байгууламжийн хангамж, нөхөн сэргээх үйлчилгээг хөгжүүлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах*
 - Дэд бүтцийн хөгжил, хүртээмж
 - Орон нутгийг чадавхжуулах

- Чадавхийг бэхжүүлэх, байгууллагын хөгжил
 - Стандарт бий болгох
4. Филиппин улсын хүүхдүүдийн аж байдлыг сайжруулахад орон нутгийн засаг захиргааны үүрэг
- Орон нутаг хүүхэд хамгааллын зөвлөл, боловсролын зөвлөл, эрүүл мэндийн зөвлөлтэй байна.
 - Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрт хүүхдийн 4 үндсэн эрхийг хангах үйл ажиллагааг оруулах
 - Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хүүхдэд чиглэлсэн төсөв мөнгийг хувиарлах
 - Хүүхдэд чиглэсэн орон нутгийн дүрэм, журмыг батлах, ХЭК болон үндэсний бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх
5. Орон нутгийн сайн засаглалын аудит

Хүүхдийн халамжийн Ерөнхий зөвлөлөөс баталсан. Зорилго нь орон нутагт хүүхдэд хүрч буй үйлчилгээг үнэлэх аудитын систем юм.12 шалгуур үзүүлэлтээс бүрдэнэ.

- 1) 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулсан хувь
 - 2) Хэвийн жингээс бага жинтэй 6 хүртэлх насны хүүхдийг бууруулсан хувь
 - 3) Өдрийн үйлчилгээнд хамруулсан 3-4 насны хүүхдийн тоог нэмсэн үзүүлэлт
 - 4) Суурь боловсролд хамруулан үзүүлэлт
 - 5) Хүүхдийн хөдөлмөрийг устгах, холбогдох кейсийг бууруулсан тоо
 - 6) Хүчирхийлэл, үл хайхрах, мөлжлөгийн золиос болсон хүүхдийн тоог бууруулсан хувь
 - 7) Орон нутаг, сургуульд хүүхдийн аюулгүй байдлыг хангасан байдал
 - 8) Хөгжлийн хөтөлбөрт хүүхдийн эрхийг хангах үйл ажиллагааг оруулсан байдал
 - 9) Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдэд туслах төвийг байгуулах
 - 10) Эхийн эрүүл мэндийн үйлчилгээ, анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн төвүүд
 - 11) Орон нутгийн боловсролын зөвлөлийн төлөвлөгөө сургуулийн үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөөтэй уялдсан байх
 - 12) Боловсролын зөвлөлийн төлөвлөгөөний хамгийн багадаа 70% нь хэрэгжсэн байна.
6. Хүүхдэд ээлтэй санаачлагад ТББ-уудын үүрэг оролцоо

Зорилтод бүлэг:

- Сургууль завсардсан хүүхэд
- Онцгой хамгаалал шаардлагатай хүүхдүүд: гудамжинд амьдарч буй хүүхэд, гэмт хэрэгт холбогдсон хүүхэд, хөдөлмөр эрхлэдэг хүүхэд, үндэсний цөөнхийн хүүхэд

Гол үйл ажиллагаа:

- Орон нутгийн дүрэм журамд нөлөөлөл хийх
 - Орон нутагт хянах бүлгийг зохион байгуулах
 - Хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг хариуцах ажлын хэсгийг зохион байгуулах
- Барангайн хүүхдийн зөвлөлийг зохион байгуулах(хүүхдийн оролцоог дэмжих)

7. Күйзан хот дахь хүүхэд, гэр бүлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төвүүдтэй танилцлаа.

Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийг саатуулах байр

БНФУ-ын Гэмт хэргийн тухай хуулиар 14-ээс доош насны хүүхдэд ял өгдөггүй, энэхүү төвд байрлуулдаг.

Үйл ажиллагаа:


- Нийгэмшүүлэх сургалт
- Боловсрол олгох
- Хөгжүүлэх сургалтууд, соёл урлагын сургалтаар дамжуулан хөгжүүлэх
- Амьдрах ухааны сургалт
- Эцэг эхэд нь зориулсан сургалт

Мансууруулах бодисонд донтсон хүүхдийг нөхөн сэргээх төв

Мансууруулах бодис (элдэв бодис үнэрлэх, бусад төрлийн мансуурах бодис)-д донтсон өсвөр насны хүүхдүүдийг энд эмчилгээнд хамруулж, мөн нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлдэг.



Мөн 2013 оны “Хүүхдэд ээлтэй” хот буюу Мандалуан хотын захиргаанаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөртэй танилцлаа.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан Т.Е.А.С.Н хөтөлбөр **T.E.A.C.H-Therapy, Education and Assimilation of Children with Handicap**

Мандалуан хотын нийт 334,188 иргэдийн 50,000 орчим нь ХБИ байдаг. Энэхүү төвд эмзэг өрхийн хүүхдүүд ирж үнэ төлбөргүй үйлчилгээ авдаг. Олон нийтэд түшиглэсэн нөхөн сэргээх, боловсролын үйлчилгээг хүргэдэг. Өдөрт дунджаар 50 орчим хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг. Хөдөлгөөн засалч, хэл засалч, нийгмийн ажилтан зэрэг мэргэжлийн хүмүүс ажилладаг. Хотын захиргаа, иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

Давао хотын Хүүхдэд ээлтэй санаачлага

Нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох хөтөлбөр:

Энэхүү хөтөлбөр нь 4-ээс дээш хүүхэдтэй гэр бүлд чиглэгдэх ба эмзэг өрхийн аж байдлыг сайжруулах зорилготой. Нэг хүүхдэд сар бүр 400 песо буюу 12000 төгрөг олгодог. Гол нөхцөл нь хүүхдээ сургуульд тогтмол хамруулах ёстой.

Давао хотын Хүүхдэд ээлтэй санаачлага



Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийг нөхөн сэргээх төв

Гэмт хэрэгт холбогдсон хүүхдэд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх, боловсрол эзэмшүүлэх, хөгжүүлэх, бие даах чадварыг эзэмшүүлэх үйлчилгээ явуулдаг. Нийгмийн ажилтнууд хүүхдийг төлөөлж шүүхийн үйл явцад оролцож, мэдээлэл өгөх зэргээр оролцох эрхтэй байдаг.



Мансууруулах бодисонд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд, насанд хүрэгчдийг нөхөн сэргээх төв

Уг төв нь хүүхэд өсвөр үеийнхэн, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд зориулсан 3 байртай. Хүүхдүүдийг насанд хүрэгчидтэй байлгах нь нийгэмшүүлэх нэг хэлбэр гэж үздэг.



Нутгийн уугуул иргэдийн хүүхдийн сургууль, дотуур байр

Нутгийн уугуул иргэд ихэнхдээ алслагдмал, уулархаг нутгаар амьдардаг. Бидний очсон Марилог дүүргийн уугуул иргэдийн хүүхдүүдэд зориулсан сургууль, дотуур байртай танилцав. Мөн явуулын бүртгэлтэй танилцлаа.

Сайн туршлага

- Орон нутгийн засаг захиргааны санаачлага маш их
 - Салбар хоорондын уялдаа холбоо, зохицуулалт сайн
 - Орон нутгийн дүрэм журам сайн хэрэгждэг
 - Хүүхдэд ээлтэй санаачлага хөтөлбөр нь барангай буюу анхан шатны нэгжид үр дүнтэй хэрэгжиж байна.
- Монгол улсад “Хүүхдэд ээлтэй хот” стратегийг хэрэгжүүлэх, гадаад орны сайн туршлагыг нийслэлд нэвтрүүлэх, хүүхдэд ээлтэй хотыг бий болгох, нийгмийн үйлчилгээнүүдийг сайжруулах, төрийн байгууллагуудын уялдаа холбоо, иргэдийн оролцоог хангах нь зүйтэй гэж үзлээ.

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
НИЙСЛЭЛИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА

Я.БАЙГАЛМАА

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

Бүгд Найрамдах Филиппин улсад томилолтоор ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. НҮБ-ын Хүүхдийн төлөө байгууллагаас Бүгд Найрамдах Филиппин улсын Манила, Давао хотуудад 2014 оны 9 дүгээр сарын 13-наас 20-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Хүүхдэд ээлтэй хотыг хэрхэн бий болгох, хот төлөвлөлтөд хүүхдийн асуудлыг хэрхэн авч үзэх” талаар туршлага судлах сургалтад Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Баярбаатар, Нийслэлийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн газрын дарга Я.Байгалмаа нарыг томилон ажиллуулсугай.

2. Сургалтын тайланг ирснээс хойш 14 хоногийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтэст ирүүлэхийг төлөөлөгчдийн ахлагч С.Баярбаатарт үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Э.БАТ-ҮҮЛ